



## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар A/96.

Улаанбаатар хот

Г Заавар батлах тухай Т

Авлигын эсрэг хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6, 18 дугаар зүйлийн 18.2.1-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн "Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг бүртгэх, хянах, хадгалах журам"-ын "Нэг. Нийтлэг үндэслэл"-ийн 1.6-д заасныг баримтлан "Мэдүүлэг гаргагчийн ... ... оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт нөхөх заавар"-ыг нэгдүгээр, "Нийтийн албанд томилогодооор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт нөхөх заавар"-ыг хоёрдугаар, "Нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарын маягт нөхөх заавар"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зааврыг үйл ажиллагаанд нэг мөр ойлгож хэрэглэх талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс (эрхэлсэн комиссар Т.Энхболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮН КОМИССАР

З.ДАШДАВАА

ХУУЛБАР ҮНЭН:  
Тамгын хэлтсийн дарга,  
эрхэлсэн комиссар

З.БААСАННЯМ



142401001158